



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот


Д.Мөнгөндүүлгыг сургалтад хамруулах  
тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академи, Бүгд найрамдах Солонгос улсын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яамны Нутгийн удирдлагын хөгжлийн институт /LOGOD/-ын хоорондын хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-д зохион байгуулагдах “Бодлогын зохицуулалт” сэдэвт сургалтад тус албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Дашдаваагийн Мөнгөндүүлгыг 2019 оны 03 дугаар сарын 10-наас 2019 оны 03 дугаар сарын 17-ны өдрийг дуустал хугацаанд хамруулсугай.

2. Д.Мөнгөндүүлгэд дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтын тайланг ирснээс хойш ажлын 5 хоногийн дотор Захиргаа, санхүүгийн хэлтэст Хүний нөөцийн Ахлах мэргэжилтэн Д.Мөнгөндүүлгэд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

